



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2008 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

“Даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох  
нөхцөл” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.2.19 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох нөхцөл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## **ДААТГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮР ЗОГСООХ НӨХЦӨЛ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос Даатгалын тухай хуулийн 14.2.19 дэх заалтыг хэрэгжүүлж, даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох гэж энэ журмын 2-т заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд Хорооноос даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид “тусгай зөвшөөрөл” гэх) бүхий даатгагчийн даатгалын тодорхой ангилал, төрөл, хэлбэрийн үйл ажиллагааг түр зогсоож, энэ хугацаанд эдгээр даатгалын ангилал, төрөл, хэлбэртэй холбоотой шинээр гэрээ байгуулах болон байгуулсан даатгалын гэрээг өөрчлөхийг хориглох, тодорхой төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахгүй байхыг хэлнэ.

### **Хоёр. Даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох нөхцөл**

2.1.Хорооны улсын ахлах байцаагч дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоож болно:

2.1.1.Даатгуулагчдын болон олон нийтийн эрх ашиг, сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал бий болсон;

2.1.2.Хорооноос даатгагчийг төлбөрийн чадваргүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж дүгнэсэн;

2.1.3.Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу Хорооноос өгсөн даалгаврыг даатгагч биелүүлээгүй, эсхүл биелүүлэх хугацаа хэтэрсэн;

2.1.4.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, эсхүл тусгай зөвшөөрлийг хуурамч баримт бичиг бүрдүүлж авсан байж болзошгүй гэдгийг шалгах шаардлагатай болсон;

2.1.5.Даатгалын компанийн хөрөнгө оруулагч, даатгагчийн эрх бүхий албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшдэг этгээдийг тус тус тохиромжтой бус этгээд гэж үзсэн;

2.1.6.Даатгагч нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангаа зохих ёсоор хөтлөөгүйгээс болж Хороонд хуурамч мэдээлэл өгсөн;

2.1.7.Холбогдох этгээдийн үйл ажиллагааг шалгах явцад Хороотой хамтран ажиллахаас татгалзсан;

2.1.8.Даатгалын эрсдэлээ хязгаарлах зорилгоор давхар даатгалын төлөвлөгөө хийгээгүй, эсхүл давхар даатгалын төлөвлөгөө нь даатгалын багц дүрэмд заасан шаардлага хангаагүй;

2.1.9.Бизнес төлөвлөгөөг дагаж мөрдөөгүй буюу хамгийн сүүлд баталсан бизнесийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг ноцтойгоор зөрчсөн;

2.1.10.Даатгалын тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу Хорооноос томилогдсон шалгагч даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох тухай дүгнэлт гаргасан;

2.1.11.Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

### **Гурав. Даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох хугацаа**

3.1.Даатгагчийн үйл ажиллагааг дараах хугацаагаар түр зогсооно:

3.1.1.Хорооноос тогтоосон хугацаагаар;

3.1.2.Хорооноос өгсөн хугацаатай үүрэг даалгавар болон Хорооноос томилогдсон шалгагчийн тавьсан шаардлагыг биелүүлэх хүртэл.

3.2.Даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох хугацаа нь 6 сараас хэтрэж болохгүй.

### **Дөрөв. Хяналт, хариуцлага**

4.1.Энэ журмын биелэлтэнд Хорооны Даатгалын газар хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн даатгагч болон даатгалын компанийн албан тушаалтныг Хорооны хяналтын улсын байцаагч Даатгалын тухай хуулийн 83.1.29-т заасны дагуу торгоно. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

4.2.Даатгалын газар Хорооноос өгсөн даалгавар болон Хорооноос томилогдсон шалгагчийн тавьсан шаардлагыг удаа дараа биелүүлээгүй даатгагчид ногдуулах албадлагын арга хэмжээний тухай санал боловсруулж Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

--ooOoo--